

Үнэнийг хэлэх (Мэдээлэх)

Бид бүх ажилтан болон бизнесийн түншүүдээсээ манай байгууллагын **Ёс зүйн дүрэмд** заасан зан байдлын хэм хэмжээний дагуу шударга байдлаар биеэ авч явахыг хүлээдэг. Хэрэв та хууль эсвэл Ёс зүйн дүрмийг зөрчсөн хэрэг үйлдэгдсэн болохыг сэжиглэж байгаа бол бидэнд үнэнийг хэлэхийг танаас хүсч байна.

Ёс зүйн дүрмийг манай дотоод сүлжээ эсвэл www.imperialbrandsplc.com сайтаас үзэх боломжтой. Дүрмийн талаархи асуултаа Governance.Team@uk.imptob.com хаягаар илгээнэ үү.

Санаа зовж буй асуудлаа хэд хэдэн сувгаар гаргаж тавих боломжтой:

1. Дотоод хүрээнд үнэнийг хэлэх

Хэрэв танд ингэх нь илүү эвтэйхэн байвал та санаа зовж буй асуудлаа хүний нөөцийн менежер эсвэл хүний нөөцийн ажилтанд тавих ёстой. Манай байгууллагад санаа зовж буй асуудлыг салбар нэгж даяар нэг мөр шийдвэрлэхэд баримтлах процесс бий.

2. Удирдах ажилтнуудад үнэнийг хэлэх

Хэрэв асуудлаа дотоод хүрээнд гаргаж тавих нь танд эвгүй санагдаж байвал эсвэл санаа зовж буй асуудлаа ингэж тавьсан ч хангалттай хариу авч чадаагүй гэж бодож байвал та доорхи албан тушаалтнуудын аль нэгэнтэй нь холбогдож болно.

- **Компанийн Нарийн Бичгийн Дарга;**
- **Группын санхүүгийн захирал;** эсвэл
- **Группын Хүний Нөөцийн Хэлтсийн Дарга.**

+44 (0)117 963 6636 дугаар руу залгаад мэдээлэл өгөх асуудал гэж хэлээрэй.

Асуудлаа бичгэн хэлбэрээр өгөхийг илүүд үзвэл та тэгж болно. Гэхдээ таньтай хэрхэн холбоо барьж болохыг бидэнд хэлээрэй. Захидлаа дараахь хаягаар илгээж болно.

The Company Secretary, 121 Winterstoke Road, Bristol BS3 2LL, United Kingdom 'Personal' гэж тэмдэглэнэ үү.	Факс: +44 (0)117 966 7859 И-мэйл: whistle.blowing@uk.imptob.com .
--	---

3. Expolink External Hotline ашиглан үнэнийг хэлэх

Түүнчлэн, та **Expolink** бие даасан үйлчилгээг ашиглан санаа зовж буй асуудлаа хэзээд ч тавьж болно. Эдгээр хүмүүстэй утас, и-мэйл эсвэл вэбээр холбогдох боломжтой. Expolink нь таны тавьсан асуудлыг зөв хүмүүс рүү нь шуурхай дамжуулж өгнө.

- Expolink шууд дугаар нь өдрийн 24 цагт, долоо хоногийн өдөр бүр (12-р сарын 25-аас бусад) ажиллана. Утасны дугаар нь улс орон бүр өөр байна. Хэрэв та зөв дугаарыг мэдэхгүй бол дотоод мэдээллийн самбар эсвэл www.expolink.co.uk, www.imperialbrandsplc.com эсвэл Группын дотоод сүлжээнээс авч болно.
- Мэдээллийг imperialtobacco@expolink.co.uk хаягаар Expolink рүү илгээж болно.
- Вэбэд суурилсан мэдээллийг Expolink-ийн www.expolink.co.uk вэбсайтаас 'imperialtobacco' гэсэн нэвтрэх кодыг ашиглан илгээх боломжтой.

Танд өгөх бидний баталгаа

Таны өгсөн мэдээллийн нууцлалыг аль болж өгөх хадгалахыг хичээнэ. Гэхдээ шалгах ажлыг зохих хэмжээнд явуулахын тулд зарим мэдээллийг задруулж магадгүй юм.

Та нэрээ нууцалсан байдлаар мэдээлэл өгөх сонголтыг хийж болох боловч ингэх нь таны ажиллаж буй улс орны хуулиар зөвшөөрөгдсөн байх ёстой.

Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсвэл зөрчсөн байж болзошгүй тохиолдлын талаар мэдээлсэн эсвэл шалгалтад тусалсан хүнээс хариугаа авахыг бид тэвчдэггүй. Гэвч, буруу санаа өвөрлөж (өш хонзон санаж) асуудлыг хөндсөн бол бид сахилгын арга хэмжээ авах болно.